

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-2

Арилжааны банкуудаас иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад олгож буй зээлийн тайланг сар бүр Монголбанк нэгтгэдэг бөгөөд энэ дугаарт БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН БАГЦЫН талаар танилцуулахаар бэлдлээ.


НИЙТ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ



Банкны зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлийн хэмжээгээр нэмэгдэж, зээлийн эргэн төлөлтөөр хасагдаж байдаг.

Банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2021 оны жилийн эцсээс 2022 оны 11 сарын эцэс хүртэл 8.6%-иар өсөж 22.4 их наяд төгрөгт хүрэв. Нийт зээлийн үлдэгдэлийн 93.5% буюу 21.0 наяд төгрөгийн зээлийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр олгосон зээл, 6.5% буюу 1.4 их наяд төгрөгтэй тэнцэх зээлийг гадаад валютаар олгосон зээл эзэлж байна.


Аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ



ААН, байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдлийг үйл ажиллагааны явуулж буй салбараар нь ангилж харвал Бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдэл хамгийн өндөр буюу 3.5 их наяд төгрөг байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудад ШИНЭЭР ОЛГОСОН ЗЭЭЛ

Банкууд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 13.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн ААН, байгууллагуудад олгосон байна. Үүний 62.5% буюу 8.3 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг Бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд олгожээ. Харин уул уурхай, боловсруулах үйлдвэр болон барилгын салбарт олгосон зээлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-2

Иргэдэд олгосон **ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ**



Арилжааны банкуудаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдэл 2022 оны Т1 сарын байдлаар 6.0 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Үүний 49.1% буюу 2.9 их наяд төгрөгийн зээл нь цалингийн зээл байна. Түүнчлэн хадгаламж барьцаалсан зээл болон малчны зээлүүд тус тус 1.1 болон 1.0 их наяд төгрөг байна.


Иргэдэд **ШИНЭЭР ОЛГОСОН ЗЭЭЛ**

2022 оны эхний Т1 сарын хугацаанд иргэдэд олгосон хэрэглээний зээлийн хэмжээ 10.3 их наяд төгрөг байна. Үүнээс 46.8% буюу 4.8 их наяд төгрөгийг хадгаламж барьцаалсан зээл хэлбэрээр олгожээ. Харин цалингийн зээлээр 2.4 их наяд төгрөгийн зээл олгосон нь нийт олгосон зээлийн 23.2%-тай тэнцүү байна.



Нийт зээлийн багц дахь **ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ**

Чанаргүй зээлийн хувь



*2022 оны Т1 сарын гүйцэтгэл

2022 оны Т1 сарын байдлаар ААН, байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдлийн 17.3% буюу 1.8 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэл нь чанаргүй гэсэн ангилалд байна. Харин иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдлийн 3.8% буюу 224 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл нь чанаргүй гэж ангилагдсан байна.

Сүүлийн 5 жилийн хугацаагаар харвал ААН, байгууллагуудын чанаргүй зээлийн хувь бага зэрэг буурсан байгаа бол үүнтэй харьцуулахад иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь 1.8%-иас 3.8% болж өссөн байна. Энэ хувь 2020 онд хамгийн дээд хэмжээндээ буюу 4.9%-д хүрч байжээ.